БТСГ
ОРХОН

# БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН БИЕИЙН ТАМИРЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫНТАЙЛАН

ХЯНАСАН:
БИЕИЙН ТАМИР,СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ДЭЛГЭРБАЯР
2025 оны 06 дугаар сарын 24

ТАЙЛАГНАСАН:
БИЕИЙН ТАМИРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ОДГЭРЭЛ
2025 оны 06 дугаар сарын 24

БИЕИЙН ТАМИРЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2025.06

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин /эхний хагас жил/ | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биел... тийн хувь |
| Зорилт 1."Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын зан төлөв насан туршийн дадал олгох зорилт бүхий биеийн тамирын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх" | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ-1.1. Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг зохион байгуулж, дүн мэдээг программд шивж, нэгтгэх; | Сорилын программд шивсэн иргэдийн мэдээллийн тоо | 8700 иргэний мэдээллийг программд шивсэн. | Сорилын программд 4500 иргэний мэдээллийг шивж оруулсан байна. | Тайлант оны эхний хагас жилд хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг аймгийн хэмжээнд 3-64 насны 4641 иргэнээс авч сорилын cpanel.sport.gov.mn программд шивсэн.<br>Биелэлт 50% | II-IV | 50 |
| 2 | Арга хэмжээ-1.2. Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн түвшнийг сайжруулах арга хэмжээ, сургалт зохион явуулах ; | Сорилд хамрагдсан иргэдээс A, B, C үнэлгээтэй иргэдийн тоо | Сорилд хамруулсан иргэдээс A-1040 B-2300 C-2502 үнэлгээ авсан иргэдийн тоо 5842 | A-540 B-1175 C-1280үнэлгээтэй A,B,C үнэлгээтэй иргэдийн тоог нийт 2995 хүргэх | Эхний хагас жилд 4641 иргэн бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсанаас 2410 иргэн буюу 51,4% нь A, B, C үнэлгээ авсан байна.<br>Хэлтсийн мэргэжилтэнгүүд Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорил авах ажлын хүрээнд ЭБЦТС-ТӨХК, Баян-Өндөр сумын ЗДТГ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, 24-р цэцэрлэгийн ажилтан, албан хаагчид, Политехникийн коллеж, Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн оюутан нийт | II-IV | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 680 хүнээс сорил авч зөвөлгөө өгч ажилласан.<br>Биелэлт 50% | | |
| 3 | Арга хэмжээ-1.3. Сумдад ажиллах биеийн тамирын арга зүйчийн тоог нэмэгдүүлэх; | Арга зүйчийн тоо | Баян-Өндөр суманд 1 арга зүйч ажилласан. | Сумдад ажиллах арга зүйчийн 1 орон тоог нэмэгдүүлсэн байна. | 2024 оны байдлаар манай аймгийн 2 сумын нэг Баян-Өндөр суманд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллаж байсан.<br>2025 оны 02 дугаар сараас эхлэн Жаргалант сумын Засаг дарга Ч.Учрал биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Жаргалант суманд Ахмадын ордон, спорт заал хариуцсан орон тооны арга зүйч-зохион байгуулагчийг томилон ажиллуулж байна.<br>Биелэлт 100% | I-IV | 10[illegible] |
| 4 | Арга хэмжээ-1.4. Аж ахуйн нэгж, байгууллагад биеийн тамирын хамтлаг, арга зүйчийн тоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах; | Биеийн тамирын хамтлаг, арга зүйчийн тоо | Байгууллагад албан ёсоор ажиллаж байгаа биеийн тамирын хамтлаг-5, байгууллагын спорт хариуцсан орон тооны бус ажилтан тоо-10 | Биеийн тамирын хамтлаг-6, байгууллагын спорт хариуцсан орон тооны бус ажилтан тоог 15 хүргэх | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 15 фитнес клубийн 6-д нь мэргэжлийн арга зүйч ажиллаж байна.<br>Төрийн байгууллагад спортын хамтлаг 5 ажиллаж албан хаагчиддаа биеийн тамир, спортын 11 арга хэмжээг хамтран зохион байгуулж ажилласан.<br>2025 онд сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад биеийн тамирын багшийн орон тоо батлагдаж манай аймагт 25 цэцэрлэгт мэргэжлийн орон тооны багш ажиллаж хүүхэд багачуудад багаас нь хөдөлгөөний эсвэл олгож дасгал хөдөлгөөнд хамруулан, биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж байна.<br>Биелэлт 100% | I-IV | 10[illegible] |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Арга хэмжээ-1.5. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа фитнес клубууд, бусад клубуудтэй хамтран ажиллах, багш, дасгалжуулагч нарт сургалт зохион байгуулсан байна; | Хамрагдсан багш, дасгалжуулагч нарын тоо | 13 фитнес клуб, 1 бужгийн холбоо | Сургалт зохион байгуулах 13 фитнес клуб, бүжгийн 1 холбоотой хамтран ажиллаж, 1 удаа сургалт зохион байгуулсан байна. | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Бялдаржуулах төв, Эргэлтэд дугуйн клубийн багш, дасгалжуулагчид, Монголын мастеруудын Биеийн тамир, спортын Орхон аймаг дахь салбар хороо, Гэрэл залуучуудын төвийн багш, ажилтнуудад "Анхны тусламжийг иргэнд үзүүлэх" сэдэвт танхимын сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр 14-16 цагт Онцгой байдлын газрын сургалтын танхимд зохион байгуулсан. Тус сургалтыг Онцгой байдлын газрын эмч, сэтгэл зүйч ахмад С.Сүхтогоо удирдан явуулж нийт 15 байгууллагын 24 багш, дасгалжуулагч хамрагдлаа.<br>2025 оны 01 дүгээр сарын 13-17-ны хооронд Биеийн тамирын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Одгэрэл Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуйн улсын байцаагч Б.Солонго, Халдварт бус өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн А.Хонгорзул, Фитнес клубийн биеийн тамирын арга хэмжээ, стандарт хариуцсан мэргэжилтэн Б.Гансайхан нарын бүрэлдэхүүнтэй 9 фитнес, 2 спиннинг клубт эрүүл ахуйн шаардлага, стандартыг хэрэгжүүлэх зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж заавар зөвлөмж өгч ажиллаа.<br>Биелэлт 100% | II-IV | 10 |
| Зорилт 2.Биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй нэг хэсэг болгож идэвхтэй хөдөлгөөнд хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх; | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Арга хэмжээ-2.1. Ахмад настнуудын биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоо, хэрэглэл материалыг нэмэгдүүлж, дэмжлэг үзүүлэх; | Арга хэмжээнд хамрагсадын тоо | Спортын 10 төрөлд 16 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 1200 ахмад настныг хамруулсан. | Спортын 8 төрөлд 8 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 650 ахмад настныг хамруулна. | Аймгийн хэмжээнд ахмад настангуудын дунд спортын 8 төрлийн (софт теннис, граунд гольф, бадминтон, хөл бөмбөг, дартс, шатар, даам, волейбол) секц дугуйланд 250 ахмадыг хамруулж заал талбай хэрэглэл материалаар хангаж ажиллалаа.<br>Эхний хагас жилд ахмадын дунд спортын 8 төрлөөр 9 удаа тэмцээн, арга хэмжээ зохион байгуулж 520 ахмад настан хамрагдсан.<br>Биелэлт 80% | I-IV | 80 |
| 7 | Арга хэмжээ-2.2. Ахмад мастеруудын спортын VIII наадамд баг тамирчдыг оролцуулж амжилтыг нэмэгдүүлэх; | Оролцогчдын тоо | 2024 онд Ахмад мастеруудын спортын VII наадамд Орхон аймгаас спортын 8 төрөлд 80 тамирчин оролцож аймгуудаас 2-р байр эзэлсэн. | Спорт зааланд ахмад тамирчдын бэлтгэл сургуулилтыг спортын 8 төрлөөр хийнэ. | Тэмцээн 08 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд Дархан-Уул аймагт зохион байгуулагдана. | III | - |
| 8 | Арга хэмжээ-2.3. Ахмад настан, тусгай хэрэгцээт иргэдийг спортоор хичээллэх, дасгал хөдөлгөөнд хамруулах нөхцөл боломжийг бүрдүүлж спортын заал танхимаар үнэгүй хангах; | Хамрагдсан иргэдийн тоо | 2024 онд 2 зааланд спортын 10 төрлөөр 750 иргэн тогтмол хичээллэсэн. | 2025 спортын заал, танхимд 400 иргэн идэвхтэй дасгал хөдөлгөөнд хамрагдан бэлтгэл сургуулилт хийсэн байна. | Ахмадуудыг БТС-ын "А" заал, Баян-Өндөр сумын спорт заал, Хангарьд спорт клуб, Эрдэнэт үйлдвэрийн Баяжуулах фабрик, Үйлдвэрчний эвлэлийн спорт заалнуудад долоо хоногт 2-3 удаа өдөрт 2 цаг спортын 6 төрлөөр үнэ төлбөргүй хичээллүүлж 260 хүн хамрагдаж байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй 240 иргэнийг БТСГ-ын А, Б зааланд спортын 8 төрлийн секц дугуйланд хамруулж заал талбай, хэрэглэл материалаар хангаж ажиллалаа. | I-IV | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Арга хэмжээ-2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоо, хэрэглэл материалыг нэмэгдүүлж, дэмжлэг үзүүлэх; | Зохион байгуулсан тэмцээн, өдөрлөгт хамрагсадын тоо | Биеийн тамир, спортын арга хэмжээг 9 төрлөөр 12 удаа тэмцээн зохион байгуулж давхардсан тоогоор 450 иргэнийг хамрагдсан. | Арга хэмжээг 8 төрлөөр 8 удаа тэмцээн зохион байгуулж давхардсан тоогоор 300 иргэнийг хамруулна. | Эхний хагас жилд тэмцээн уралдаан, бусад арга хэмжээг иргэдийн дунд спортын 9 төрлөөр 9 удаа зохион байгуулж 260 иргэдийг хамрууллаа. Арга хэмжээнүүдэд улс орон нутгийн төсвөөс нийт 5,438,000 төгрөг зарцуулсан.<br>Эхний 5 сард зохион байгуулсан тэмцээн, арга хэмжээ:<br>-02 дугаар сард зохион байгуулсан "Эрдэнэт Мөнгөн өвөл" арга хэмжээний хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд Гүйлтийн цаныг тэмцээнийг амжилттай зохион байгуулж 19 тамирчин оролцож 2 алт, 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртсэн.<br>-02 дугаар сард Орхон аймагт зохион байгуулагдсан Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII наадмын Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн дунд зохион байгуулагдсан цасны гуталтай гүйлт, гүйлтийн цанын төрлүүдэд манай аймгаас эрэгтэй 2, эмэгтэй 2 нийт 4 тамирчин оролцож 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлсэн.<br>-03 дугаар сард Итали улсын Турин хотод зохиогдсон Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн Олимпид Орхон аймгаас гүйлтийн цанын төрлөөр 3 тамирчин, 1 дасгалжуулагч амжилттай оролцож 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн.<br>-Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадмын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд Пара хөнгөн атлетик, Тусгай хөнгөн атлетикийн сонгон шалгаруулах тэмцээнийг 2025 оны 04 | I-IV | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүгээр сарын 18-29-ний өдрүүдэд Хангарьд спорт цогцолборын Хөлбөмбөгийн талбайд зохион 5 багийн 78 тамирчин, 04 дүгээр сарын 29-нд сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд Диф 3x3 сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж 32 тамирчин тус тус оролцсон. Тэмцээний зардалд өсвөрийн шигшээ багийн зардлаас нийт 3,200,000 төгрөг зарцуулсан.<br>-04 дүгээр сарын 17-ний өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд "Нөхөрсөг Бөчи" тэмцээнийг "А" зааланд зохион байгуулж тэмцээнд 65 гаруй Тусгай хэрэгцээт хүүхэд, иргэд, багш нар хамрагдсан.<br>-05 дугаар сарын 24-нд Суугаа волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг "А" зааланд зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгч 6 багийн 40 тамирчин оролцсон.<br>-05 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар улсын хэмжээнд зохион байгуулж буй "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд "Эрдэнэт марафон-2025" бүх нийтийн гүйлт зохион байгуулагдсан. Гүйлтийн үеэр Тусгай олимпын иргэдийн дунд 500м-ийн гүйлтийг явуулж 32 тамирчин оролцлоо.<br>-06 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд Хонхтой бөмбөгийн 9 дэх удаагийн улсын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аварга шалгаруулах тэмцээнийг Орхон аймагт амжилттай зохион байгуулж Орхон, Завхан, Булган, Хэнтий, Дорнод, Говьсүмбэр, Дундговь, Төв аймаг, Улаанбаатар хот Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбооны эрэгтэй 10, эмэгтэй 6 багийн нийт 90 тамирчин оролцлоо. Биелэлт 100% | | |
| 10 | Арга хэмжээ-2.5. Дэлхийн Тусгай олимпийн өвлийн наадамд баг тамирчдыг оролцуулах, Тусгай олимпийн Зүүн ази бүсийн МАТР олон улсын сургалт, арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулах; | Арга хэмжээг зохион байгуулсан байна. | - | Сургалтыг III улиралд аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллана. | Хугацаа болоогүй | III | – |
| 11 | Арга хэмжээ-2.6 "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд Төрийн албан хаагчдын ажлын байрны дасгалын уралдаан зохион байгуулах; | Дасгал хөдөлгөөнд хамрагдсан иргэдийн тоо | Ажлын байрны дасгал"-ын цахим дасгалын уралдаанд 4500 ажилтан албан хаагч оролцсон. | Арга хэмжээг IV улиралд зохион байгуулна. | Хугацаа болоогүй | IV | – |
| 12 | Арга хэмжээ-2.7. "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд Төрийн албан | Хамрагдсан иргэдийн тоо | 26 байгууллагын 400 албан хаагч хамрагдсан. | I улиралд зохион байгуулж төрийн байгууллагууд | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд төрийн байгууллагын албан хаагчдын дунд "Цасны баяр 2025" биеийн | I | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хаагчдын дунд "Цасны баяр" арга хэмжээг багийн болон үндэсний спортын 4 төрлөөр тэмцээн зохион байгуулах; | | | ын албан хаагчдыг хамруулна. | тамирын өдөрлөг арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Сархиа цанын баазад зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд олс таталт, хөгжөөнт буухиа, тэшүүрийн 4x100, гүйлтийн цанын 4x100 төрлүүдээр тэмцээн, уралдааныг зохион байгуулж 16 байгууллагын 422 албан хаагч хамрагдсан. Тус үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 2,490,000 төгрөгийг зарцуулсан.<br>Биелэлт 100% | |
| 13 | Арга хэмжээ-2.8. "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд бүх нийтийн "Эрдэнэт марафон" гүйлтийн арга хэмжээ зохион байгуулах; | Хамрагдсан иргэдийн тоо | 1 удаа зохион байгуулж 250 хүн хамрагдсан. | Арга хэмжээг 5 дугаар сард зохион байгуулж 300 хүн оролцуулна. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд "Эрдэнэт марафон-2025" бүх нийтийн гүйлтийн арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 18-ны өдөр 5 км, 10 км, 21 км, Гэр бүлийн гүйлт 1500м, Тусгай олимпын иргэдийн 500м-ийн зэрэг 5 зай төрөлд 7 насны эрэгтэй, эмэгтэй ангиллаар зохион байгуулагдаж, Орхон, Булган, Хөвсгөл аймгийн нийт 239 тамирчин оролцлоо. Тус биеийн тамирын арга хэмжээний шагнал, урамшуулалд орон нутгийн төсвөөс 5,285,000 төгрөгийг зарцуулсан.<br>Биелэлт 100% | II |
| 14 | Арга хэмжээ-2.9 "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд | Хамрагдсан иргэдийн тоо | - | III улиралд зохион байгуулна. Аймгийн хэмжээний | Хугацаа болоогүй. | III |

101

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сургуулийн сурагчдын дунд зохион байгуулах буухиа тэмцээн | | | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулж 300 хүүхэд хамруулсан байна. | | | — |
| 15 | Арга хэмжээ-2.10. "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд сурагчдын дунд "Нэг анги-нэг өглөө" биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулах; | Хамрагдсан иргэдийн тоо | Ерөнхий боловсролын сургуулиудын 2-5 дугаар ангийн сурагчдын дунд "Нэг анги-Нэг өдөр" цахим дасгалын арга хэмжээнд 22 сургуулийн 85 бүлгийн 18000 сурагч оролцсон. | Арга хэмжээг хэмжээг IV улиралд зохион байгуулж Ерөнхий боловсролын сургуулийн 18100 сурагч хамруулна. | Хугацаа болоогүй. | IV | — |
| 16 | Арга хэмжээ-2.11. Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд Жаргалант сумын иргэдийн дунд биеийн тамир, спортын өдөрлөг зохион байгуулах; | Хамрагдсан иргэдийн тоо | Биеийн тамирын өдөрлөг"-ийн арга хэмжээнд 6 багийн 60 тамирчин хамрагдсан. | II улиралд зохион байгуулж арга хэмжээнд 10 багийн 100 хүн оролцуулна. | Аяныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчдын дунд олс таталт, хөгжөөнт буухиа, дартсын тэмцээн, 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд гар дээр суниалтын тэмцээнийг эрэгтэй, эмэгтэй ангиллаар амжилттай зохион байгуулж давхардсан тоогоор 113 тамирчин оролцсон.<br>Биелэлт 100% | II | 10é |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Арга хэмжээ-2.12. Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд иргэдийн дунд биеийн тамирын өдөрлөг зохион байгуулах; | Хамрагдсан иргэдийн тоо | Эртэч Эрдэнэтчүүд" Өглөөний дасгалын өдөрлөг, арга хэмжээнд давхардсан тоогоор 2400 иргэн хамрагдсан. | Өдөрлөг, арга хэмжээнд 2500 иргэн хамруулсан байна. | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагын дунд "Цасны баяр-2025" биеийн тамирын арга хэмжээ, иргэд олон нийтийн дунд "Зөв гүйе" биеийн тамирын арга хэмжээ, "Эрдэнэт-Марафон-2025" бүх нийтийн гүйлт, Бүх нийтийн явган алхалт, Эртэч Эрдэнэтчүүд өглөөний дасгал зэрэг арга хэмжээнд давхардсан тоогоор 3000 гаруй иргэнийг хамруулсан байна.<br>Биелэлт 100% | I-IV | 100 |
| 18 | Арга хэмжээ-2.13. Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд биеийн тамирыг дэмжигч байгууллага, клубуудын дунд иргэдийн дунд биеийн тамирын өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах; | Хамрагдсан иргэдийн тоо | Фитнесс клуб болон нийтийн биеийн тамирыг дэмжигч байгууллагууд ын дунд спортын 3 төрөлтийн тэмцээн зохион байгуулж 10 багийн 120 тамирчин оролцсон. | II улиралд зохион байгуулна. Аймгийн Фитнесс клуб болон нийтийн биеийн тамирыг дэмжигч байгууллагууд ын дунд арга хэмжээ зохион байгуулж 140 иргэний хамруулна. | Аяны хүрээнд эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлж дадал болгох, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Биеийн тамирыг дэмжигч байгууллагуудын дунд (фитнес клубууд, алхалтын холбоо, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо Шугаман бүжгийн холбоо) спортын 3 төрөлт тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээнд 10 байгууллагын 90 гаруй тамирчин амжилттай оролцлоо<br>Биелэлт 100% | IV | 100 |
| 19 | Арга хэмжээ-2.14. "Иргэдийн спортын наадам"-ыг үндэсний болон | Зохион байгуулсан спортын төрөл, | 2024 онд Иргэдийн спортын наадмыг Баян-Өндөр, | IV улиралд спортын хэлтэстэй хамтран зохион байгуулна. | Хугацаа болоогүй | IV | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | багийн спортын 4 төрлөөр зохион байгуулах; | хамрагсадын тоо | Жаргалант сумын 26 багийн иргэдийн дунд багийн болон үндэсний спортын 8 төрлөөр зохион байгуулж 1163 иргэн хамруулсан. | | | | - |
| 20 | Арга хэмжээ-2.15. Явган алхалтын аймгийн аварга шалгаруулах тэмцээн болон алхалтын бусад арга хэмжээг зохион байгуулах; | Хамрагдсан иргэдийн тоо | 2024 онд явган алхалтын арга хэмжээг 4 удаа зохион байгуулж 420 иргэнийг хамруулсан. | Явган алхалтын арга хэмжээг 3 удаа зохион байгуулж, 400 иргэнийг хамруулна. | Эхний хагас жилд 3 удаагийн алхалтын арга хэмжээг зохион байгуулж иргэдийг идэвхтэй хөдөлгөөнд хамрууллаа.Үүнд:<br>1.Аймгийн Явган алхалтын холбоотой хамтран улсын хэмжээнд "БҮХ ХАЙРАА ГЭР БҮЛДЭЭ-100км замын алхалт"-ын арга хэмжээг амжилттай зохион байгуулж Дорнод, Багахангай, Архангай, Өвөрхангай, Дархан, Орхон аймаг,Улаанбаатар хотын алхагч 100 гаруй хүн<br>2."Эрүүл Монгол Хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Бүх нийтийн явган алхалт"-ын арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр хооронд А.Амарын талбайгаас Сархиа-Уулын чиглэлд зохион байгуулж нийт 12 байгууллагын 210 ажилтан албан хаагч, 300 гаруй иргэд оролцлоо.<br>3.Бурхан Багшийн Их Дүйчэн өдрийг угтан Гороо-Эко алхалт 06 дугаар сарын 03-нд зохион байгуулагдаж 60 гаруй иргэн тус тус хамрагдлаа.<br>Биелэлт 100% | II-III | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | Арга хэмжээ-2.16. "Зөв гүйе" арга хэмжээг аймгийн хэмжээнд сурталчлан зохион байгуулах, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын биеийн тамирын багш нарт сургалт зохион байгуулах; | Хамрагдсан иргэдийн тоо | - | Төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагч, иргэд, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын биеийн тамирын багш нарыг хамруулна. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол Хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Гүйж сурья" биеийн тамирын арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Биеийн тамир, спортын газрын Б зааланд 7 хоног бүрийн Бямба, Ням гарагуудад өглөө бүр 07:20-08:30 цагуудад иргэдэд үнэ төлбөргүй зохион байгуулсан. Арга хэмжээнд 48 байгууллага, иргэд зэрэг давхарлсан тоогоор 500 гаруй хүн хамрагдсан.<br>Мөн Шугаман бүжгийн сургалтыг Төгөлдөр-Солонго бүжгийн клубтэй хамтран Пүрэв, Бямба, Ням гарагуудад өглөө бүр 08:00 цагаас үнэ төлбөргүй зохион байгуулж байна. Арга хэмжээнд давхардсан тоогоор 1000 гаруй иргэн тогтмол хамрагдсан. Тус арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл Хангарьд спорт цогцолборын гадна хөлбөмбөгийн талбайд зохион байгуулж, иргэд олон нийтийг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаа.<br>"Зөв гүйе" биеийн тамирын арга хэмжээний чиглэлээр сургуулийн өмнөх боловсролын байгууллагын биеийн тамирын багш, арга зүйч, эмч нарт 10 дугаар сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>Биелэлт 100% | II | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | Арга хэмжээ-2.17. Идэвхтэй хөдөлгөөн, дасгалын ач холбогдлыг сурталчилж төрийн болон төрийн бус байгууллагуудад сургалт арга хэмжээ зохион байгуулах; | Зохион байгуулсан сургалтын тоо | 2024 онд 1 удаа сургалт зохион байгуулсан. | Идэвхтэй хөдөлгөөн, дасгалын ач холбогдлыг сурталчилсан сургалтыг 2 удаа зохион байгуулна. | Орхон аймгийн волейболын холбоо, Монголын ахмад мастеруудын нэгдсэн волейболын холбоо хамтран зохион байгуулсан "Волейболын шүүгчийн анхан шатны сургалт" 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 03 дугаар сарын 21-ний өдрүүдэд биеийн тамир спортын газрын А зааланд зохион байгуулсан.Тус сургалтад Орхон аймгаас 9, Хөвсгөл аймгаас 5, нийт 14 хүн хамрагдаж, Олон Улсын волейболын дүрэм, шүүгчийн дүрэмтэй танилцаж, практик дадлага хийн батламжаа гардан авсан.<br>"ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН" үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн Шугаман бүжгийн холбоотой хамтран 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийг дуустал "Шугаман бүжиг"-ийн үнэ төлбөргүй сургалтыг 7 хоног бүрийн Пүрэв, Бямба, Ням гарагуудад 08:00 цагаас "Төгөлдөр-Солонго" бүжгийн клубт зохион байгуулж байна. Тус арга хэмжээнд 1000 гаруй иргэн хамрагдсан.<br>Биелэлт 100% | I-IV | 10i |
| 23 | Арга хэмжээ-2.18. Орон сууцны болон гэр хорооллын дундах спорт, чөлөөт цагийн талбайн ашиглалтыг сайжруулж биеийн тамир спортын уралдаан | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2024 онд гадаа талбайд 13 удаа арга хэмжээ зохион байгуулж 7720 иргэнийг хамруулсан. | 2025 онд гадаа талбайд 10 удаа тэмцээн уралдаан, арга хэмжээ зохион байгуулж, 5000 иргэнийг хамруулна. | Тайлант оны эхний хагас жилд амралт, чөлөөт цагийн талбайн ашиглалтыг сайжруулж 7 удаагийн тэмцээн уралдаан, арга хэмжээнд 1759 иргэдийг хамруулсан.Үүнд:<br>-"Эртэч Эрдэнэтчүүд" өглөөний дасгалын арга хэмжээнд 260 иргэн; | I-IV | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмцээнийг зохион байгуулах; | | | | -Хүүхдийн баярын 06 дугаар сарын 01-ний өдрийн арга хэмжээний хүрээнд сагсан бөмбөгийн 3х3 төрөл, даамын тэмцээнд 500 хүүхэд;<br>-Бүх хайраа гэрбүлдээ арга хэмжээний нээлтийн хүрээнд сагсан бөмбөгийн 3х3 төрлөөр U12 насны тэмцээнд 50 багийн 200 хүүхэд;<br>-"Эрдэнэт марафон-2025" бүх насны гүйлтийн уралдаанд 239 хүүхэд, залуус;<br>-Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын үдэлт, хаалтын арга хэмжээнд спортын 30 төрлийн 350 өсвөрийн тамирчид;<br>-"Эрүүл Монгол үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд "Бүх нийтийн явган алхалт"-н арга хэмжээнд 12 байгууллагын 210 албан хаагч тус тус оролцсон.<br>Биелэлт 70% | | 70 |
| 24 | Арга хэмжээ-2.19. Спортын хэрэгслийн /ердийн болон цахилгаан дугуй, цана, тэшүүр, дугуйт цана, дугуйт тэшүүр/ түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжих; | Түрээсийн үйлчилгээ үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн тоо | 2024 онд 5 байршилд 6 иргэн, аж ахуйн нэгж спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан. | Спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжин ажиллана. | Тайлант оны эхний хагас жилд өвлийн спортын 3 байршилд 3 иргэн аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээнд 4200 иргэдийг хамруулсан. Үүнд:<br>-Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-н Сархиа баазад цана чарганы түрээсийн үйлчилгээнд 2000 гаруй иргэн<br>-Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 1000 гаруй хүүхэд залуус | I-IV | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Орос 19 дүгээр сургуулийн мөсөн талбайд тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 1200 хүүхэд залуус тус тус үйлчлүүлсэн.<br>Биелэлт 70% | | |
| 25 | Нийтийн цэнгээнт бүжиг, шугаман бүжгийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын холбоодтой хамтран зохион байгуулах, улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдыг оролцуулах | Хамрагдсан иргэдийн тоо | 2024 онд аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2 удаа зохион байгуулж 154 тамирчин оролцсон.Шугаман бүжгийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 10 тамирчин амжилттай оролцсон. | Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 1 удаа зохион байгуулж 100 тамирчин оролцуулна.Шугаман бүжгийн улсын аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдыг амжилттай оролцуулна. | Цэнгээнт бүжгийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 04 дүгээр сард амжилттай зохиогдон 12 багийн 120 гаруй тамирчин хамрагдсан.<br>Шугаман бүжгийн улсын аварга шалгаруулах тэмцээн 02 дугаар сард Улаанбаатар хотод зохиогдон манай аймгаас Төгөлдөр Солонго клубын баг тамирчид амжилттай оролцож тэргүүн байр эзэлсэн.<br>Биелэлт 70% | I-IV | 70 |
| Зорилт-4. Спортын сургалтын дасгалжуулалтын үйл ажиллагааг сайжруулж, тамирчдын авьяасыг нээн илрүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэн, тэмцээн уралдаанд оролцох оролцоог нэмэгдүүлж, амжилт гаргах нөхцөлийг бүрдүүлэх; | | | | | | | |
| 26 | Арга хэмжээ-4.2. Аймгийн Засаг даргын 2015 оны А/445 дугаар захирамжийн дагуу спортын өндөр амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад жил бүр мөнгөн урамшуулал олгуулах; | Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчдын тоо | 2023 онд улсын аварга шалгаруулах тэмцээнээс ахмад 58 тамирчин медаль хүртэж 2,650,000 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 9 тамирчин 750,000 сая | 2024 онд улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд журмын дагуу хүрээнд мөнгөн урамшуулал | Аймгийн Засаг даргын 2015 оны А/445 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу<br>2024 онд өндөр амжилт гаргасан 430 тамирчин, спортын шилдэг 5 төрийн бус байгууллага, 5 дасгалжуулагчдын материалыг<br>журмын дагуу хүлээн авч нэгтгэн 77,980,000 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгуулахаар судалгааг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст | | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төгрөгийн мөнгөн урамшуулал авсан. | олгуулсан байна. | хүргүүлсэн.Одоогоор мөнгөн урамшуулал олгогдоогүй байна .<br>Биелэпт 90% | | |
| 27 | Арга хэмжээ-4.4. Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII наадмыг Орхон аймагт зохион байгуулахад ажил үүргийн хуваарийн дагуу хамтран ажиллах, өвөл, зуны спортын наадамд хөгжлийн бэрхшээлтэй баг тамирчдын бэлтгэл сургуулилтыг ханган оролцуулах; | Спортын наадмаас авсан медалийн тоо | 2023 онд зохиогдсон Монголын Хүүхдийн спортын өвлийн VII наадамд спортын 5 төрөлд 54 тамирчин оролцуулж, багийн дүнгээр 4-р байранд шалгарсан. | Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII наадмыг орон нутагт зохион байгуулахад ажиллах, хөгжлийн бэрхшээлтэй баг тамирчдыг спортын 7 төрлөөр бэлтгэн оролцуулсан байна. | Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII наадам манай аймагт Сархиа цанын баазад 2025 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 02 дугаар сарын 20-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулагдсан. Тэмцээнд 13 аймаг, 6 дүүргийн 209 тамирчид оролцсон ба манай аймгаас спортын 5 төрөлд 73 тамирчин, 10 дасгалжуулагчийг бэлтгэн оролцуулж, 10 алт 13 мөнгө 9 хүрэл нийт 32 медаль хүртсэн амжилтаар аймгуудын багийн дүнгээр 2-р байр эзэлж, цом, өргөмжлөлөөр шагнагдсан.<br>Тус тэмцээний үеэр хэлтсийн мэргэжилтэнгүүд даргын баталсан ажил үүргийн хуваарийн дагуу сайн ажилласан.<br>Монголын хүүхдийн спортын зуны VIII дугаар наадмын шигшээ тэмцээнд Орхон аймгаас спортын 30 төрөлд 297 тамирчин, 51 дасгалжуулагчдыг бэлтгэн оролцуулж, алтан медаль 15, мөнгөн медаль 15, хүрэл медаль 25, нийт 55 медаль хүртсэнээр 21 аймгийн багийн дүнгээр 1-р байр эзэлж, цом, өргөмжлөлөөр шагнагдсан амжилтыг үзүүлсэн. Тэмцээний үеэр мэргэжилтэнгүүд 05 дугаар сарын 26-ны өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд спортын төрлүүдийг хариуцан ажилласан.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бэлтгэл сургуулилтыг амжилттай хийлгэж шигшээ тэмцээнд спортын 7 төрлөөр 38 | | 10Г |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тамирчин амжилттай оролцож 4 алт, 3 мөнгө, 4 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүллээ.<br>Биелэлт 100% | | |
| 28 | Арга хэмжээ-4.7. Монголын Бүх ард түмний спортын зуны XVI наадмын хүрээнд анхан шатны тэмцээн, шигшээ тэмцээнд баг тамирчдыг бэлтгэн оролцуулах; | Оролцсон тамирчид, спортын наадмаас авсан медалийн тоо | 2022 он зохион байгуулагдсан их наадамд спортын 3 төрлөөр амжилттай оролцож 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн. | III улиралд зохион байгуулагдана. Аймгийн Спортын 3 төрлөөр баг тамирчдыг оролцуулахаар холбогдох холбоодтой хамтран ажиллаж, тамирчдын бэлтгэл сургуулилтыг хийлгэнэ. | Хугацаа болоогүй.<br><br>Тэмцээнд хонхот бөмбөг, суугаа волейбол, хөнгөн атлетикийн төрлөөр баг тамирчдыг оролцуулахаар бэлтгэж байна. | | - |
| 29 | Арга хэмжээ-4.9. Төрийн албан хаагчдын дунд спортын 4 төрлөөр тэмцээн зохион байгуулахад хамтран ажиллах | Зохион байгуулсан тэмцээн, оролцогчдын тоо | 2024 онд Спортын 4 төрөлд 699 албан хаагч оролцуулан зохион байгуулсан. | Төрийн албан хаагчдийн волейболын тэмцээнийг II улиралд спортын хэлтэстэй хамтран зохион байгуулна. | Орхон аймгийн ИТХ-ын нэрэмжит Төрийн албан хаагчдын волейболын тэмцээн 05 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж 32 байгууллагын эрэгтэй, эмэгтэй 40 багийн 320 тамирчин оролцсон.<br>Тэмцээнд хэлтсийн мэргэжилтэнгүүд даргын баталсан ажил үүргийн хуваарийн дагуу ажлаа гүйцэтгэж, хангалттай сайн ажилласан.<br>Биелэлт 100% | | 10( |
| Зорилт-5. Спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, шинээр хөгжиж байгаа болон цахим, хотын /урбан/ спортын төрлүүдийг сурталчлан эрүүл, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэдийн тоог нэмэгдүүлэх; | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | Арга хэмжээ-5.**1.** Биеийн тамир, спортын төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, үр дүнг тооцон ажиллах; | Спортын өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулсан байна. | Шинээр хөгжиж байгаа болон хотын спортын 8 төрөлд 650 тамирчин хичээллэж, нөлөөллийн арга хэмжээг 2 удаа зохион байгуулсан. | Спортын өдөрлөг,арга хэмжээг 8 удаа зохион байгуулж, биеийн тамир, спортоор хичээллэх иргэдийн тоог нэмэгдүүлсэн байна. | Тайлант оны эхний хагас жилд шинээр и-спорт, гараар таталт, пара бөчигийн төрлүүдийг шинээр хөгжүүлж, тусгай бөчи, корн-holl, мас-рестлинг, гар дээр суниалт, дартсын спортын 8 төрөлд 275 тамирчин биеийн тамир, спортын газрын А, Б заал, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н спорт цогцолборын заалнуудад 7 хоногт 6 өдөр 2 цагаар тогтмол хичээллэж байна.Спортын шинээр хөгжүүлж буй 6 төрөлд 12 удаагийн тэмцээн зохион байгуулж, 616 иргэд, тамирчдыг хамруулсан.Үүнд:<br>-Модон барилдаан өсвөр үе, насанд хүрэгчдийн аймгийн шалгаруулах тэмцээнд 80 тамирчин;<br>-Бөчигийн аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит 2 удаагийн тэмцээнд 96 тамирчин;<br>-Корн холлын 3 удаагийн тэмцээнд 150 тамирчин;<br>-Дартсын спортын төрлөөр 3 удаагийн тэмцээнд 200 тамирчид тус тус хамрагдсан.<br>Биелэлт 100% | | 10 |
| 31 | Арга хэмжээ-5.**2.** Мэргэжилтэн тус бүр хариуцсан чиг үүргийн дагуу спортоор хичээллэж буй байгууллага, спорт холбоод, клуб, спортын төрөл, хичээллэгчдийн | Гэрээ байгуулсан спорт холбоодын тоо | 2024 онд 10 төрийн бус байгууллагатай хамтран ажилласан. | 7 төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, хамтран ажиллана. | Биеийн тамирын хэлтэс нь эхний хагас жил ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, явган алхалт, бүжгийн спортын холбоо нийт 7 холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулан даргаар батлуулан ажиллаж аймгийн хэмжээнд иргэдэд чиглэсэн биеийн тамирын арга хэмжээг хамтран зохион байгуулан ажиллаж байна. | | 7[illegible] |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоон судалгааг насны ангилал, хүйсээр гарган ажиллах; | | | | Мэргэжилтэнгүүд хариуцсан чиг үүргийн дагуу төрийн байгууллагын спорт хамтлаг, фитнес клуб, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гарган ажиллаж байна.<br>Биелэлт 70% | | |
| 34 | Арга хэмжээ-6.2. Баримт бичгийг архив, албан хэрэг хөтлөлтийн журам, баримт бичгийн стандартын дагуу боловсруулах, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах; | Журмын хэрэгжилтийн хувь | 2024 онд албан хэрэг хөтлөлтийг цаасаар болон цахимаар хөтөлж эхэлсэн. | Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын хэрэгжилтийг хангаж баримт бичгийг цахимаар явуулж хэвшүүлнэ. | Өдөр тутмын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг и-офисс программ цахимаар гүйцэтгэж хэрэгжилт 70% байна. | | 70 |
| 35 | Арга хэмжээ-6.3. Хэлтсийн хэмжээнд 2025 онд үүсэж хөтлөгдсөн бичиг баримт, тайлан, бусад цаасан баримтыг холбогдох стандарт журам, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын архивт дагуу хүлээлгэн өгнө. | Баримт бичгийн тоо | 2024 онд хэлтсийн хэмжээнд үүсэж хөтлөгдсөн 11 баримт бичгийг архивт хүлээлгэн өгсөн. | 2025 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу үүссэн 13 баримт бичгийг архивт хугацаанд нь хүлээлгэн өгнө. | Байгууллагын ББНШК-ын 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хурлаар хэлэлцэж баталсан "Биеийн тамирын хэлтсийн 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ын дагуу хэлтсийн хэмжээнд нийт 13 баримтыг бүрдүүлэн ажиллана.<br>Биелэлт 70% | | 70 |
| 36 | Арга хэмжээ-6.4. Байгууллагын удирдлагын шийдвэрээр ажлын | Хэлтсийн 5 мэргэжилтэн | Орон тооны бус зөвлөл, комисст ажиллаж үйл | Орон тооны бус зөвлөл, комисст ажиллаж үйл | Байгууллагын даргын тушаалаар Эцэг, эхийн зөвлөл, Ёс зүйн зөвлөл, Даргын зөвлөл зэрэг орон тооны бус зөвлөлүүдэд ажиллаж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэсэг, комисс, зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллаж, хэрэгжилтийг хანган ажиллах; | | ажиллагааг сайжирсан байна. | ажиллагааг сайжирсан байна. | "Ёс зүйн дэд хороо" 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Тайлант онд байгууллагын "Ёс зүйн дэд хороо" нь 11 ажил зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж эхний хагас жилд 7 ажлыг хэрэгжүүлэн ажилласан.<br>Эцэг, эхийн зөвлөл 14 ажил хийхээр төлөвлөн батлуулж ажлын гүйцэтгэл эхний хагас жилд 70% байна.<br>Биелэлт 70% | | 70 |
| 37 | Арга хэмжээ-6.5. Байгууллагын мэдээллийн веб сайт, сошиал сүлжээнд албанаас зохион байгуулсан арга хэмжээний мэдээ мэдээллийг тухай бүр оруулж, ил тод байдыг хангана. | Мэдээллийн тоо | Байгууллагын пэйж хуудас, фэйсбүүк группт 80 мэдээлэл оруулж, 16500 иргэд, сурагчид, тамирчдад сурталчлан ажиллалаа. | Зохион байгуулсан арга хэмжээний мэдээ, мэдээллийг байгууллагын пэйж хуудас, фэйсбүүк группт 100 удаа оруулж 20,000 иргэнд сурталчилсан байна. | Байгууллагын болон хэлтсийн хэмжээнд зохион байгуулж байгаа арга хэмжээ, мэдээ мэдээллийг тухай бүр БТСГ-ын ажилчид, БТСГ биеийн тамирын хэлтэс фэйс группт сурталчлан ажиллаж нийт 105 удаа мэдээлэл оруулж иргэдэд хүргэсэн.<br>Биелэлт 70% | | 70 |
| 38 | Арга хэмжээ-6.6. Аймгийн хэмжээнд ашиглаж байгаа И-оффис программыг албан хэрэглээнд өдөр тутам хэрэглэх; | И-оффис программын ашиглалтын хувь | 2024 онд и-оффис программд 22 албан бичиг төлөвлөн шийдвэрлүүлж, 46 албан бичигт санал өгч, 4 өргөдөл, гомдол, санал шийдвэрлэж, 179 албан | И-оффис системийн ашиглалтыг өдөр бүр ашигласан байна. | Хэлтсийн мэргэжилтэнгүүд и-оффис программыг өдөр тутам албан хэрэглээнд ажиглаж байна.<br>Эхний хагас жилд хэлтсийн хэмжээнд 9 тушаал, 24 албан бичиг төлөвлөж шийдвэрлэж ажилласан бйана.<br>Эхний хагас жилд ирсэн гомдол, санал байхгүй.<br>Биелэлт 70% | | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бичиг шийдвэрлэж хаасан. | | | | |
| 39 | Арга хэмжээ-6.7. Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, бусад холбогдох чиг үүргийг тухай бүр хэрэгжүүлж ажиллах; | Үүрэг даалгаврын хэрэгжилт | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан. | Өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан байна. | Хэлтсийн мэргэжилтэнгүүд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байна. Арга хэмжээ, спортын их наадмуудад даргын баталсан ажил үүргийн хуваарийн дагуу ажиллаж, албан үүргээ хангалттай гүйцэтгэсэн. Биелэлт 100% | | 10i |

ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | |
|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт |
| 1 | 2 | 3 | 4 |
| "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШ ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: | | | |
| 1 | Орон нутаг, байгууллагаас зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана. | Тухай бүр хамрагдсан байна. | Аймгийн Төрийн албаны зөвлөл, Эрүүл мэндийн газар, Хүүхэд, бүл, хөгжил хамгааллын газар зэрэг байгууллагуудаас ажилын үүргийн хүрээнд зохион байгуулсан 8 удаагийн сургалт а хэмжээнд оролцсон.<br>Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн ёс з тухай хууль тогтоомж, бодлого төлөвлөгөөний хэрэгжилт, хян шалгалтын үр дүн, ёс зүй сахилга хариуцлагыг чанаржуу зорилгоор "Бүсчилсэн хөгжил - Төрийн албаны манлайлал" х бүсийн төрийн албан хаагчдын зөвлөгөөн Орхон аймагт 04 дүг сарын 07-08-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 5 албан хаагч хамт оролцож төрийн албаны хууль тогтоомж, түүнтэй уял, гарсан журмуудын талаар мэдээлэл авсан. |

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Биелэлт | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Ажлын байран дээрээ surgalt.gov.m платформоос мэдээллийн технологийн 14 хичээлийг судалсан байна. | Аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар зөвлөмж | судалсан хичээлийн тоо, эзэмшсэн чадвар | - | Ажлын байран дээрээ surgalt.gov.m платформоос мэдээллийн технологийн хичээлийг судалж ажлын байран дээрээ хэрэгжүүлэн ажиллаж байна. | 2025.01.02 | 2025.12. |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 9 зорилгыг хэрэгжүүлэх | Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 02 дугаар албан даалгавар | хийсэн ажлын тоо | - | Зорилтыг хэрэгжүүлж, өдөр тутам үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | 2025.01.02 | 2025.12. |
| 3 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Хамт олны шуурхайн хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт | Хамт олны шуурхайн хурал дарга Д.Дэлгэрбаяр | Ажлын тайлан | 2024 онд байгууллагын шуурхайн хурлаас өгсөн үүрэг даалгаврын тухай бүр хэрэгжүүлэн ажилласан. | Хамт олны шуурхайн хуралд 8 удаа сууж даргын өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан. | 2025.01.02 | 2025.12. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Хойд бүсийн аймгуудын дунд зохион байгуулагдсан бүсчилсэн хөгжил "Иргэдийн спортын наадам" | | | | Хойд бүсийн аймгуудын дунд зохион байгуулагдсан бүсчилсэн хөгжил "Иргэдийн спортын наадам" үндэсний болон спортын 7 төрөлд 15 насны (сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис 19-30 нас, 31-44 нас, +45-аас дээш нас, шатар, үндэсний бөх 18-аас дээш нас, шагайн харваа 19-55 нас, 56-аас дээш нас, үндэсний сурын харваа 18-25 нас, 26-аас дээш нас) ангиллаар Булган аймагт 2025 оны 05 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд зохион байгуулагдлаа.<br>Оркон аймгаас тус бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 136 тамирчин оролцож алтан медаль 16, мөнгөн медаль 6, хүрэл медаль 4 тус тус хүртэж багийн нийлбэр дүнгээр тэргүүн байранд шалгарсан.<br>Бүсчилсэн хөгжлийн "Иргэдийн спортын наадам"-д баг, тамирчдыг оролцуулахад орон нутгийн төсвөөс хоол, унааны зардалд 10,700,000 төгрөг, тамирчдын бие халаалтын хувцасны зардалд Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газраас 6,400,000 төгрөг, Жаргалант сумын Засаг даргын тамгын газраас 3,840,000 | 2025.05.02 | 2025.05. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн тус тус үзүүлсэн.<br>Бүсчилсэн хөгжлийн "Иргэдийн спортын наадам"-ын хойд бүсийн аймгуудын дунд зохион байгуулагдсан тэмцээнд тэргүүлсэн баг, тамирчид шигшээ тэмцээнд оролцох батламжаа гардан авлаа. Бүс тус бүрээс шалгарсан багийн тэмцээн 2025 оны 08 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулагдана. | | |

----oOo----

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Монгол бичгийн мэдлэгээ сайжруулж бие даан суралцана. | Дунд түвшний мэдлэг, чадвартай болсон байна. | Монгол бичгийн сургалтанд цахимаар хамрагдаж мэдлэ сайжруулсан. Цахим орчинд монгол бичгээр бичсэн үг, өгүүлб мэдээг тогтмол уншиж байна. |
| 3 | ЗГХА-БТСУХ-ноос зохион байгуулах цахим болон танхимын сургалт, зөвөлгөөнд тухай бүр оролцоно. | Салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа шинэ мэдээ, арга хэмжээг тухай бүр авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан байна. | ЗГТА-БТСУХ-ноос цахимаар зохион байгуулсан 5 удааг сургалт, зөвөлгөөнд оролцож мэдээлэл авсан.<br>Монгол Улсын Засгийн газраас 2025 онд Бүсчилсэн хөгжл дэмжих жил болгон зарласантай холбогдуулж Биеийн там спортын улсын хорооноос Биеийн тамирын арга зүйч н "Идэвхтэй хөдөлгөөн, Эрүүл амьдралын хэв маяг" зан үйл талаар мэдлэг олгох онол болон дадлага хосолсон төвийн бүс сургалт 06 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд Дархан-уул аймг Биеийн тамир, спортын газар зохион байгуулагдаж байгууллагь мэргэжилтэний хамт амжилттай оролцож Сертификат авсан. |

ХЯНАСАН:
ДАРГА Д.ДЭЛГЭРБАЯР

ТАЙЛАН БИЧСЭН:
БИЕИЙН ТАМИРЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.ОДГЭРЭЛ